



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2011 оны 07 сарын 20 өдөр

Дугаар 07/198

Мандалговь

“Соёмбо мандал” ХХК-тай
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалт, аймгийн тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Аймгийн угтах, үдэх газрын тохижилт”-ын ажлыг 199,950,000 (нэг зуун ерэн есөн сая есөн зуун тавин мянга) төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн үнийн саналаар “Соёмбо мандал” ХХК-тай 199,950,000 (нэг зуун ерэн есөн сая есөн зуун тавин мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан зураг, төсвийн дагуу ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Соёмбо мандал” ХХК-ийн захирал (Д.Бямбабаяр)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4822150479